

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаангом сумын Ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/118/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаангом хот
2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг:
BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Ахлах аудитор: Т.Намжил

Утас: 70453721, Цахим хаяг: NamjilT@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

УЛААНГОМ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 6 ДУГААР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Ч.БАТТОГТОХ ТАНАА

2023.02.15 № УВА-2023/118/НА-СТА-ТЧЗ
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаангом сумын Ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаангом сумын Ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Улаангом сумын Ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн захирал өөрчлөгдсөн байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

0200200281

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

A handwritten signature in black ink is written over a red square official stamp. The stamp contains Mongolian text and a central emblem. The signature is written in a cursive style.

М.БАТСУУРЬ

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	11
4. Аудитын тайлан	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. Аудитын илрүүлэлт	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	136,337,419	157,684,336.55
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	37,098,068
31211	Төрийн сангийн харилцах	00.00	37,098,068
35	БАРАА МАТЕРИАЛ	136,337,419	120,586,268.55
351	Түүхий эд материал	18,178,900.20	24,224,728.64
35110	Тусгай зориулалттай материал	18,178,900.20	24,224,728.64
35130	Эм боох материал	00.00	00.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	00.00	00.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	00.00	00.00
354	Хангамжийн материал	118,158,518.80	96,361,539.91
35410	Бичиг хэргийн материал	12,000.00	00.00
35420	Аж ахуйн материал	120,000.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	118,026,518.80	96,361,539.91
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,062,152,675.42	3,007,644,994.39
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,062,152,675.42	3,007,644,994.39
392	Биет хөрөнгө	2,708,938,453.22	2,655,002,994.39
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,633,519,685.67	2,624,295,931.67
39202	Хуримтлагдсан элэгдэл	-197,327,523.46	-266,176,375.79
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	433,858,342.07	464,812,391.54
39206	Хуримтлагдсан элэгдэл	-255,673,031	-269,118,863.94
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	130,038,226.40	141,138,226.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	-92,903,842.10	-102,771,329.93
39217	Ном	57,426,595.94	62,823,014.44
393	Биет бус хөрөнгө	353,214,222.20	352,642,000.00
39301	Програм хангамж	2,850,000.00	2,900,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,227,777.80	-2,850,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	352,592,000.00	352,592,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,198,490,094.42	3,165,329,330.94
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,198,490,094.42	3,165,329,330.94
51	Засгийн газрын хувь оролцоо	3,198,490,094.42	3,165,329,330.94
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,207,633,684.03	2,207,633,684.03
51101	Өмч: - төрийн	2,207,633,684.03	2,207,633,684.03
512	Хуримтлагдсан үр дүн	104,788,079.08	71,627,315.60
51210	Өмнөх үеийн үр дүн	104,788,079.08	104,788,079.08
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-33,160,763.48
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	886,068,331.31	886,068,331.31
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,198,490,094.42	3,165,329,330.94

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,822,910,186.76	2,080,614,827.24
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,809,881,855.76	79,135,727.24
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,809,881,855.76	79,135,727.24
120	Нийтлэг татварын бус орлого	229,622,608.76	79,135,727.24
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	223,385,886.44	71,588,688.80
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,888,444.00	15,085,670.00

1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		13,356,600.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	209,734,164.76	52,693,457.24
122	Тусламжийн орлого	202,508,447.00	
	Төсвөөс санхүүжих	202,508,447.00	
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,377,750,800.00	
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	1,377,750,800.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	13,028,331.00	2,001,479,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		1,763,053,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		1,763,053,500.00
	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,028,331.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,500,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,600,000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	928,331.00	
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		238,425,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		238,425,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,673,996,731.33	2,112,050,687.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,673,996,731.33	2,112,050,687.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,609,973,694.33	1,965,674,040.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,113,658,080.00	1,342,805,751.00
210101	Үндсэн цалин	788,521,652.00	943,226,307.00
210102	Нэмэгдэл	250,633,570.00	345,288,880.00
210104	Урамшуулал	74,502,858.00	54,290,564.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	145,671,794.00	167,959,842.00
210201	Тэтгэврийн даатгал	103,421,794.00	115,623,889.20
210202	Тэтгэмжийн даатгал	10,976,100.00	13,440,945.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,781,200.00	10,788,776.58
210204	Ажилгүйдлийн даатгал	2,261,300.00	2,555,202.52
210205	Эрүүл мэндийн даатгал	20,231,400.00	25,551,027.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	194,508,947.00	191,937,792.00
210301	Гэрэл, цахилгаан	4,754,313.00	8,720,732.00
210302	Түлш, халаалт	177,275,648.00	177,275,648.00
210303	Цэвэр, бохир ус	12,478,986.00	5,941,412.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,870,967.40	39,200,558.89
210401	Бичиг хэрэг	1,482,260.00	94,900.00
210402	Тээвэр, шатахуун	2,830,000.00	1,053,170.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,046,194.00	
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,609,000.00	651,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,145,110.00	10,444,400.00

210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
210408	Бараа материал акталсны зардал	4,758,403.40	26,957,088.89
2105	Нормативт зардал	967,950.00	540,650.00
	Эм	547,950.00	540,650.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	420,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,749,500.00	10,040,000.00
210604	Урсгал засвар	8,749,500.00	10,040,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,151,000.00	
210702	Дотоод албан томилолт	2,151,000.00	
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,939,400.00	21,153,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	550,000.00	5,826,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	806,400.00	806,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	583,000.00	14,521,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	121,456,055.93	192,035,846.76
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		38,926,650.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,542,160.00	21,816,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	107,913,895.93	131,293,196.76
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	64,023,037.00	146,376,647.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	53,894,750.00	145,098,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	41,867,750.00	145,098,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,027,000.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,128,287.00	1,278,647.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,128,287.00	1,278,647.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	148,913,455.43	-31,435,860.41
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	1,466,444.56	1,724,903.07
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,466,444.56	1,724,903.07
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-1,466,444.56	-1,724,903.07
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	147,447,010.87	-33,160,763.48

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1,613,176,022.00	2,027,921,370.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,613,176,022.00	2,027,921,370.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,600,147,691.00	26,442,270.00
	Нийтлэг татварын бус орлого	19,888,444.00	26,442,270.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	19,888,444.00	26,442,270.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,888,444.00	15,085,670.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		11,356,600.00
122	Тусламжийн орлого	202,508,447.00	
	Төсвөөс санхүүжих	202,508,447.00	

123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,377,750,800.00	
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	1,377,750,800.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	13,028,331.00	2,001,479,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		1,763,053,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	1,763,053,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,028,331.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,500,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,600,000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	928,331.00	
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		238,425,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		238,425,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,613,176,022.00	1,990,823,302.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,613,176,022.00	1,990,823,302.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,549,152,985.00	1,844,446,655.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,,113,658,080.00	1,342,805,751.00
210101	Үндсэн цалин	788,521,652.00	943,226,307.00
210102	Нэмэгдэл	250,633,570.00	345,288,880.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	74,502,858	54,290,564.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	145,671,794.00	167,959,842.00
210201	Тэтгэврийн даатгал	103,421,794.00	115,623,889.20
210202	Тэтгэмжийн даатгал	10,976,100.00	13,440,945.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,781,200.00	10,788,776.58
210204	Ажилгүйдлийн даатгал	2,261,300.00	2,555,202.52
210205	Эрүүл мэндийн даатгал	20,231,400.00	25,551,027.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	194,508,947.00	191,937,792
210301	Гэрэл, цахилгаан	4,754,313.00	8,720,732.00
210302	Түлш, халаалт	177,275,648.00	177,275,648.00
210303	Цэвэр, бохир ус	12,478,986.00	5,941,412.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,675,004.00	
210401	Бичиг хэрэг	1,482,260.00	
210402	Тээвэр, шатахуун	2,830,000.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,046,194.00	
210404	Ном, хэвлэл	776,000.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,609,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,931,550.00	
2105	Нормативт зардал	1,638,350.00	
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	470,350.00	

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,168,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,328,400.00	10,040,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,828,900.00	
210602	Тавилга	12,500,000.00	
210604	Урсгал засвар	7,999,500.00	10,040,000.00
210702	Дотоод албан томилолт	2,151,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,939,400.00	20,397,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	550,000.00	5,826,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	806,400.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	583,000.00	14,571,000.00
210807	Газрын төлбөр		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,582,010.00	111,306,070.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		89,418,170.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	26,582,010.00	21,887,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	64,023,037.00	146,376,647.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	53,894,750.00	145,098,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	41,867,750.00	145,098,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,027,000.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,128,287.00	1,278,647.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,128,287.00	1,278,647.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)		37,098,068.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		37,098,068.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		37,098,068.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл					
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл					
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00

C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн					
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,207,633,684.03	886,068,331.31	104,788,079.08		3,198,490,094.42
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	2,207,633,684.03	886,068,331.31	104,788,079.08		3,198,490,094.42
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,207,633,684.03	886,068,331.31	104,788,079.08		3,198,490,094.42
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00		-33,160,763.48		-33,160,763.48
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,207,633,684.03	886,068,331.31	71,627,315.60		3,165,329,330.94

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ЭЗА	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,027,919,900.00	1,989,544,655.00	38,375,245.00

21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,027,919,900.00	1,990,823,302.00	37,096,598.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,881,645,500.00	1,844,446,655.00	37,198,845.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,350,489,900.00	1,342,805,751.00	7,684,149.00
210101	Үндсэн цалин	1,019,026,500.00	943,226,307.00	75,800,193.00
210102	Нэмэгдэл	318,482,000.00	345,288,880.00	-26,806,880.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт			
210104	Урамшуулал	12,981,400.00	54,290,564.00	-41,309,164.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	169,138,100.00	167,959,842.00	1,178,258.00
210201	Тэтгэврийн даатгал	115,133,400.00	115,623,889.20	-490,489.20
210202	Тэтгэмжийн даатгал	13,520,100.00	13,440,945.80	79,154.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,809,400.00	10,788,776.58	20,623.42
210204	Ажилгүйдлийн даатгал	2,697,800.00	2,555,202.52	142,597.48
210205	Эрүүл мэндийн даатгал	26,977,400.00	25,551,027.90	1,426,372.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	193,216,200.00	191,937,792.00	1,278,408.00
210301	Гэрэл, цахилгаан	5,500,000.00	8,720,732.00	-3,220,732.00
210302	Түлш, халаалт	177,275,600.00	177,275,648.00	-48.00
210303	Цэвэр, бохир ус	10,440,600.00	5,941,412.00	4,499,188.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,040,000.00	10,040,000.00	
210604	Урсгал засвар	10,040,000.00	10,040,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,419,000.00	20,397,200.00	21,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,826,200.00	5,826,200.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	14,592,800.00	14,571,000.00	21,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	138,342,300.00	111,306,070.00	27,036,230.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	111,453,000.00	89,418,700.00	27,034,830.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,889,300.00	21,887,900.00	1,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	146,274,400.00	146,376,647.00	-102,247.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	146,274,400.00	145,098,000.00	1,176,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	146,274,400.00	145,098,000.00	1,176,400.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,027,919,900.00	2,026,642,723.00	-1,470.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,763,053,500.00	1,763,053,500.00	
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,763,053,500.00	1,763,053,500.00	
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	238,425,600.00	237,146,953.00	
132001	Орон нутгийн төсвөөс	238,425,600.00	237,146,953.00	
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	26,440,800.00	26,442,270.00	-1,470.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,084,200.00	15,085,670.00	-1,470.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,356,600.00	11,356,600.00	

5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		37,098,068.00	-37,098,068.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО			
610001	Төсвийн байгууллага			
610002	Төсвөөс гадуур байгууллага			
62	АЖИЛЛАГСДЫН ТОО			
620001	Удирдах ажилтан	1	1	
620002	Гүйцэтгэх ажилтан	74	74	
620003	Үйлчлэх ажилтан	13	13	
620004	Гэрээт ажилтан			

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Мэргэжлийн багийн хамтын ажиллагаа, багшийн арга зүйн хөгжлийг дэмжиж сургалтын чанарт ахиц гаргах зорилготой байгууллага юм.

Зорилт:

1. Мэргэжлийн багийн хамтын ажиллагаа, багшийн арга зүйн хөгжлийг дэмжиж, ЭЕШ, гүйцэтгэлийн үнэлгээнд бодит ахиц гаргах.
2. Суралцагчдын ялгаатай түвшинг оношлон суурь түвшинг ахиулах.
3. Нэгжийн үнэлгээний гүйцэтгэлийн үр дүнд хяналт хийх тогтолцоог бүрдүүлэх.
4. Хичээл сургалт болон, хичээлээс гадуурх ажил, анги нийтээр хамтран бие хүний ур чадварт суралцаж, өөрийн удирдлагатай суралцахуйг эрхэмлэн суралцах.
5. Ахлах ангийн суралцагчийн мэргэжил, хичээл сонголтод арга зүйн зөвлөгөө өгч, сонгох хичээлийн гүйцэтгэлийг нэмэгдүүлэх.
6. Хүүхэд хамгааллын үйлчилгээг олон нийтийн идэвхтэй үйл ажиллагаагаар тэгш, хүртээмжтэй хүргэх.
7. Багш өөрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулж ,ажлын байран дээрээ хөгжиж, туршлагаа түгээн дэлгэрүүлэх.
8. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах.
9. Сургалтын байгууллага хоорондын хамтын ажиллагаа, сургуульд суурилсан менежментийг сайжруулахад багш, сурагч, эцэг эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх.
10. Багш, ажилтан бүр ёс зүйн хэм хэмжээг эрхэмлэн, харилцааны дүрмийг мөрдөж, сургуулийн соёлыг бий болгон ажиллах.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулахад Боловсролын хууль, Хөдөлмөрийн хууль, Төсвийн хууль, Бага дунд боловсролын хууль зэрэг хууль тогтоомжийг мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль - 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.

- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Улаангом сумын Ерөнхий боловсролын 6-р сургуульд тайлант онд дотоод аудит хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаангом сумын Ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна. Тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улаангом сумын Ерөнхий боловсролын 6-р сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 33,160.8 мянган төгрөгөөр буюу 1 хувиар өссөн байна. Энэ нь үндсэн хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		37,098.0	37,098.0
Авлага			
Бараа материал	136,337.4	120,586.3	-15,751.1
Үндсэн хөрөнгө	3,062,152.7	3,007,645.0	-54,507.7
Нийт хөрөнгө	3,198,490.1	3,165,329.3	-33,160.8
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,198,490.1	3,165,329.3	-33,160.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,198,490.1	3,165,329.3	-33,160.8

Тайлант оны эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 37,098.0 мянган төгрөг байгаа нь нөхөн хангалтын зардалын зарцуулагдаагүй үлдэгдэл байна.

Бараа материал дансны үлдэгдэл 120,586.3 мянган төгрөг болж 15,751.1 мянган төгрөгөөр буурсан нь бусад хангамжийн бараа материал акталснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,007,645.0 мянган төгрөг болж 54,507.7 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгө акталсан болон элэгдлийн зардалтай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь 33,064.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 250.0 мянган төгрөгийн ном, 50.0 мянган төгрөгийн программ худалдан авсан, 45,146.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, ном, сурах бичгийг үнэ төлбөргүй хүлээн авснаар нэмэгдэж, 40,233.7 мянган төгрөгийн акталсан хөрөнгө, 131,293.2 мянган төгрөгийн элэгдлийн зардлаар хасагдсан байна.

Тайлант оны эхэнд болон эцэст өр төлбөр байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,165,329.3 мянган төгрөг болж 33,160.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Энэ нь үндсэн хөрөнгө акталсан болон элэгдлийн зардалтай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвийн 1,908,414.8 мянга, үйл ажиллагааны орлогоос 19,648.0 мянга, нийт орлогыг 1,928,062.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,928,062.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас улсын төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийн зардлыг 358,309.7 мянган төгрөгөөр бууруулж 1,569,753.1 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь боловсрол шинэчлэлийн хүрээнд зардлын зүйл ангийг өөрчилсөнтэй холбоотой зарим зардлыг танасан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг нэмэгдүүлэн нийт 2,027,919.9 мянган төгрөг болгон тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,763,053.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 238,425.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 26,440.8 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,763,053.5 мянга, орон нутгийн төсвөөс 238,425.6 мянга, өөрийн орлогоос 26,442.3 мянга, нийт 2,027,921.4 мянган төгрөгийн санхүүжилт бүрдүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,989,544.6 мянган төгрөг буюу 98.1 хувьтай байна. тогтмол зардлын зарцуулагдаагүй үлдэгдэл 1,278.6 мянган төгрөгийг төвлөрүүлжээ. Мөн мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 37,098.1 мянган төгрөг байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Байр ашиглалтын үйлчилгээ	5,837.1	5,837.1	0.00	100
2	Сургалт	2,918.6	2,890.1	28.50	99.0

/мянган төгрөгөөр/

3	Эрүүл мэндийн арга хэмжээ	6,712.7	6,658.0	54.70	99.2
4	Үдийн цай	146,274.4	145,098.0	1,176.4	99.2
5	Боловсролын стандарт сургалтын төлөвлөгөө хөтөлбөр	1,441,856.7	1,434,203.1	7,653.6	99.5
6	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	86,380.4	85,148.6	1,231.8	98.6
7	Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтын орчинг сайжруулах	20,614.6	20,613.7	0.9	100
8	Сурах бичгийн түрээс	5,826.2	5,826.2	0.00	100
9	Хүүхдэд ээлтэй орчин	59,940.0	33,064.0	26,876.0	55.2
10	Боловсролын байгууллагын багш	13,133.6	13,058.8	74.8	99.4
11	Байр ашиглалттай холбоотой зардал	203,256.2	201,977.8	1,278.4	99.4
12	Нийтлэг үйлчилгээ	35,169.4	35,169.4	0.00	100
	Нийт	2,027,919.9	1,989,544.7	38,375.2	98.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улаангом сумын Ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Намжил гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаангом сумын Ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 11 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож,

материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 8,369.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн үе шатанд 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,112,050.7 мянган төгрөгийн 0.5 хувь буюу 10,560.2 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 8,448.2 мянган төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Улсын бүртгэлийн хэлтсийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Улаангом сумын Ерөнхий боловсролын 6 дугаар сургууль нь тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 149, хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Улаангом сумын Ерөнхий боловсролын 6 дугаар сургууль нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Улаангом сумын Ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Улаангом сумын Ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөрчил илрээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар зөрчил гараагүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.БАТСУУРЫ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

Л.НАМЖИЛ/

2023 оны 02 сарын 14-ний өдөр